

сахиулах их сургууль болон Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн хамтран туршилт, судалгаа, сургалт зохион байгуулахад ашиглах,

2D панорам систем нь хямд учир өргөнөөр ашиглаж эхлэх/ жишээ нь цагдаагийн газар, хэлтэс бүрт ашиглах/, энэ нь цаашид 3D лазер сканерын системийг ашиглах урьдчилсан бэлтгэл болох.

3D хэмжээст лазер сканерын системийг юуны өмнө онц ноцтой гэмт хэрэг, тээврийн хэрэгслийн осолын шалтгаан нөхцлийг тогтооход ашиглаж эхлэх,

3D лазер сканер системийг үе шаттайгаар хууль сахиулах үйл ажиллагаанд нэвтрүүлэх хөтөлбөрийг боловсруулах.

Ном зүй

http://en.wikipedia.org/wiki/History_of_forensic_photography

<https://ecrimescenechemistrymiller.wikispaces.com/Perkins+and+Hollis+Forensic+Photography>

<http://www.3rdtech.com/>

<http://psg.leica-geosystems.us/page/scanstation-3d-laser-scanners/>

<http://faro.by/kriminalistika>

ГЭМТ ХЭРЭГ ИЛРҮҮЛЭХЭД ГРАФОЛОГИЙН ШИНЖЛЭХ УХААНЫГ АШИГЛАХ НЬ USE SCIENCE OF GRAPHOLOGY FOR DETECTION OF CRIME



Ж.ӨНГӨТХҮҮ ХСИС-ийн Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэнгийн Шинжлэн магадлахуй төвийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, цагдаагийн хошууч

UNGUTKHUU J. Senior researcher of the Forensic Examination Studies center, Research and Development Institute, Law enforcement University, Police major

Товч агуулга: Хүний бичиг, гарын үсгийн хэв түүний шинж тэмдэгт дүн шинжилгээ хийх замаар хувь хүний зан чанар, сэтгэл санааны өөрчлөлтийг судалдаг мэдлэгийн салбарыг “графологи” гэж нэрлэдэг. Графологийн мэдлэгийг барууны өндөр хөгжилтэй орнуудад гэмт хэрэг илрүүлэхэд өргөнөөр ашигладаг туршлагыг өөрийн оронд нэвтрүүлэх шаардлагатай.

Abstract: A knowledge branch that studies character and psychology changes of an individual by the way of analyzing the style of human handwriting and signature, and its features named as graphology. It is required to introduce the experience of broad use of graphology for detection of crime in developed western countries


Түлхүүр үг: Графологи, Мастер граф, програм, элемент, криминалистикийн, хэл шинжлэл, шүүх-бичиг техник

Судалгааны зорилго: Монгол улсын Хууль сахиулах байгууллагууд, Шүүхийн шинжилгээний байгууллагад Графологийн шинжлэх ухааныг гэмт хэрэг илрүүлэхэд ашиглах боломжтой эсэхийг судлахад оршино.

Гэмт хэрэг илрүүлэх, таслан зогсооход бид бичгийн хэлбэр, утга санаа болон гарын үсгээр бичиг судлалын шинжилгээ хийдэг.

Гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох мөрдөхөд

хүний гарын үсэг болон гар бичмэлээр хувь хүний талаарх бүрэн мэдээллийг агуулдаг графологийн шинжлэх ухааныг АНУ, ХБНГУ, Франц, БНХАУ, ОХУ, Казахстан, Беларусь зэрэг оронд өргөнөөр ашиглаж байна. Хүн бүр өөрийн гэсэн давтагдашгүй, харьцангуй тогтвортой бичгийн хэлбэрийг агуулдаг. Хүний бичгийн хэв тухайн бичигчийн хувийн зан чанар, амьдралын хэв маяг, мэргэжил боловсролыг түвшин, удам угсаа, яс үндэс, нас хүйс, сэтгэл зүйн өөрчлөлт зэрэг олон мэдээллийг өөртөө агуулсан байдаг.



Графология буюу бичгийн хэв судлал нь харьцангуй хожуу судлагдсан шинжлэх ухаан хэмээн тооцогддог. Графологи түүний судлах зүйлийн талаарх ойлголт ХҮП зуунд хамрагдах ба үндэслэгчээр нь гэгээнтэн Мишоныг /1806-1881/ зүй ёсоор тооцдог. Тэрээр нийгмийн графологийн боловсролыг санаачлагч, энэ сэдвээр хэд хэдэн өгүүлэл бичсэн бөгөөд анхны графологийн тусгай сэтгүүлийг гаргаж байжээ.

Графологийн хөгжилд дараачийн ач холбогдолтой алхмыг Францад Кремпье-Жамены бүтээлүүд хийсэн. Өөрийн хамгийн алдартай бүтээлдээ тэрээр графологийн хуулиудын тэмдэглэсэн шинжлэх ухааны өгүүлийг багтааж байжээ. Түүний «Бичгийн хэв ба зан чанар» гэсэн том бүтээлтэй нэгэн зэрэг Италийн нэрт эрдэмтэн Ч.Ломброзо, Германы профессор В.Прейерийн ажлууд хэвлэгдсэн байна.

Баруунд графологийн нийгэмлэг, хүрээлэнгүүд байгуулагдаж, практик түршлагаар баяжигдсан графологийн бүтээлүүд олон олноор гарах болсон. Жишээ нь, 1926 онд шүүхийн анагаах ухааны профессор С.Оттоленгийн «Бичгийн хэвний дүн шинжилгээ ба зураасны адилтгал» ном хэвлэгдсэн байв.

1923 онд Орос улсын сэтгэц-неврологийн академиас графологийн хуулиудыг өргөн судалж, тэдгээрийг улсын хууль зүйн болон туршилтын сэтгэл судлал, криминологи гэх мэтэд хэрэглэх шаардлагатайг тэмдэглэсэн. Энэ үеэс олон нэрт мэргэжилтнүүд Д.М.Зуева-Инсарова, П.В.Рышков, М.И.Поняловский нарын ажлууд хэвлэгдэн гарч, профессор С.Оттоленгийн бүтээл орос хэлээр орчуулагдан, Ф.Ф.Германы графологийн тухай сонирхолтой ном хэвлэгдсэн.

Графологийн шинжлэх ухааныг барууны улс орнуудад 1920 оны үеэс эхлэн гэмт хэрэгтэй тэмцэх зорилгод нийцүүлэн ашиглаж байсан түүх баримтууд олон тохиолдож байлаа.

Харин хуучин ЗХУ-д гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох ажилд тэр бүр ашигладаггүй тагнуулын байгууллага \КГБ\ -ын үйл ажиллагаанд өндөр нууцлал бүхий ЗХУ-ын КГБ-ын Криминалистикийн

шинжилгээний лабораторид хийдэг байсан.

Сүүлийн үед 1990 оноос хойш дэлхий улс гүрнүүд даяаршлагдсан цаг үеэс графологийн шинжлэх ухаан эрчимтэй хөгжиж олон арван эрдэмтэн судлаачид энэ чиглэлээр бүтээл туурвиж байна. Жишээ нь Илья Щеголев, Кравченко Владимир Иосифович, Алексковский Сергей Юрьевич, Д. М. Рамендик, М. Г. Рамендик С. Дороти. И. Моргенштерн В. Маяцкий И. Моргенштерн В. И. Гарбузов нарыг нэрлэж болно.

Сүүлийн жилүүдэд “Криминалистикийн графологи”-ийн шинжлэх ухааныг гэмт хэрэг илрүүлэх, мөрдөх ажиллагааны үед хэрэгт ач холбогдол бүхий нөхцөл байдлыг тогтоох зорилгоор ашиглах арга, барил, хэрэгслийг судалдаг графологи зүйн мэдлэгийн салбар бий болоод байна.

Шүүхийн шинжилгээ зүйн доктор Алексковский Сергей Юрьевич ЗХУ-ын КГБ-ын сургуулийн шинжээчийн ангийг төгсөж Аюулаас хамгаалах байгууллагад 30-аад жил шинжээчээр ажилласан, 20 гаруй жилийн турш графологийн сэдвээр эрдэм шинжилгээ судалгааны ажил хийж байгаа бөгөөд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, олон оронд явж лекц уншиж, графологийн шинжилгээг урилгаар хийдэг эрдэмтэн графологийн шинжлэх ухааныг хөгжүүлэхэд өөрийн мэдлэг чадвар, оюун ухаан бие сэтгэлээ зориулж байгаа эрдэмтэн хүн Казахстан улсад амьдарч байна.

Графологи зүй нь сэтгэц судлалын шинжлэх ухаан, хэл шинжлэлийн шинжлэх ухаан, хууль зүйн шинжлэх ухааны нийлбэр цогцод оршиж буй танин мэдэхүйн салбар юм. Тийм болохоор эдгээр болон бусад шинжлэх ухааны хүрээнд бий болсон мэдлэгийн тогтолцоо нь графологи зүйг бий болгон хөгжүүлэх, түүний арга зүйг гэмт хэрэгтэй тэмцэх практикт ашиглах шинжлэх ухааны үндэс, онолын бааз суурь нь болж байгаараа өвөрмөц шинжтэй.

Хууль бус аливаа үйлдэл болон ийм үйлдлийн тухай мэдээлэл нь хүний мэдрэл-сэтгэхүйд тусгал хэлбэрээр үлдэж тодорхой нөхцөл үүсгэх үед сэтгэцэд нөлөөлөл үзүүлэх, тухайлбал сандрал, айдас, цочрол болон үйл хөдлөлийн өөрчлөлт гэх мэтэд хүчин зүйлс нөлөөлдөг графологи зүйг ашиглах шинжлэх ухааны ерөнхий үндэс болдог.

Графологийн арга: Хүний бичиг, гарын үсгийн хэв түүний шинж тэмдэгт дүн шинжилгээ хийх замаар хувь хүний зан чанар, сэтгэл санааны өөрчлөлтийг судалдаг мэдлэгийн салбарыг “графологи” гэж нэрлэдэг. Графологийн мэдлэгийг барууны өндөр хөгжилтэй орнуудад, тусгай албад өргөн ашиглаж байна.

Шүүх-бичиг техник судлалын шинжилгээний явцад ч графологийн аргыг хэрэглэх тохиолдол ихээр гардаг. Графологийн аргыг ашиглан тодорхой нэр хаяггүй, гар бичмэл болон бичиг баримтыг тухайн хүн үйлдсэн эсэх, гар бичмэл болон бичиг баримтыг

үйлдэх үе дэх зохиогч, бичигчийн сэтгэл зүйн байдал, түүний амьдралын хэв маяг, ёс суртахууны өвөрмөц онцлог зэргийг ямар нэгэн хэмжээгээр тодорхойлох боломжтой болохыг гадаадын орнуудын практик харуулж байна.

Гар бичмэл болон гарын үсгээр нь хувь хүнийг тодорхойлох графологийн арга нь хувь хүний гарын үсэг болон гар бичмэлийн ерөнхий болон хувийн онцлог шинж тэмдгүүдээр тухайн хүний сэтгэл зүйд нөлөөлөх нөлөөллийг ашигладаг далд оношилгооны аргуудын нэг бөгөөд тэргүүлэх байр суурийг эзэлдэг. Уг аргыг ашиглах үйл явц нь ямар нэгэн хүндрэл бэрхшээл, хөрөнгө мөнгө зарахгүй шүүх-бичиг техникийн шинжилгээний аргаар гачлалыг нарийвчлан бичгийн хувийн онцлог шинж тэмдгүүдийг хүний сэтгэл зүйтэй хослуулан хэрэглэснээрээ түүний давуу тал бөгөөд шинжилгээний үнэн бодитой, найдвартай байх магадлал нь 90 % -д хүрч байна.

Хүний гарын үсэг болон гар бичгийн хэвээр хувь хүний дараах онцлогийг тодорхойлж болдог:

- 1) Ажиллах чадвар, удирдах болон гүйцэтгэх албан тушаалд ажиллах хүсэл эрмэлзлэл;
- 2) Түрэмгийлэх шинж, зөрчилтэй нөхцөл байдалд илрэх зан төлөв;
- 3) Чиглэсэн зорилго, тэвчээр, шургуу зан.

Гарын үсгээр тухайн хүнийг тодорхойлж болно.

1. Гарын үсгийн хэмжээ
Гарын үсгийн эхний элемент нь уншигдах бусад элемент нь үл уншигдах таталсан жижиг хэмжээтэй гарын үсэг нь өөрийн гэсэн бодолтой хүнийг өөртөө татаж, хүрээлүүлэх чадвартай, асуудлыг нийтэд нь хамарсан системтэй, тодорхой зорилготой сэтгэлгээг харуулна.
2. Гарын үргэлжлэх хэмжээ
Урт үргэлжилсэн гарын үсэг нь аливаа асуудлын гүнд орох чадвартай, тогтвортой зантай, эмзэг, үглээ нуршаа
- Богинохон гарын үсэг нь хурдан ойлгоцтой, сэтгэлгээ хурдан, нэг хэвийн хэв загварт баригдахыг хүсдэггүй
Дунд зэргийн урттай гарын үсэг нь шийдвэр гаргахдаа удаан, нэг гаргасан шийдвэр үзэл бодолдоо үнэнч зөрүүд зантай
3. Гарын үсгийн үсгийн хэлбэр дүрс
Мөрийн элемент болон дээд, доод элемент нь хурц өнцөггүй, дугариг хэлбэртэй гарын үсэг нь уян налархай, тогтвортой зан төлөвтэй
Мөрийн элемент болон дээд, доод элемент нь хурц өнцөгтэй, тасалдсан дугариг хэлбэртэй

гарын үсэг нь догшин шүрүүн, дураараа, нэр төрд дуртай, тэвчээр хатуужил багатай

4. Үсгийн холбоос, үсэг хоорондын зай
- Үсгийн холбоос урт, үсэг хоорондын зай хол бол уужуу тайван, тооцоо муу үрэлгэн
- Үсгийн холбоос богино, үсэг хоорондын зай шигүү, үсгийн хэмжээ жижиг бол анивч хямгач
5. Гарын үсэг дахь чимэглэл:
- Үсгүүд нь тойрог ихтэй үйлдэгдсэн бол шинэлэг сэтгэлгээтэй, шинийг илэрхийлэгч
- Үсгүүд нь гогцоо ихтэй үйлдэгдсэн нь өөрийн гэсэн бодолтой ямар ч үед ямар нэгэн аргаар өөрийн бодлоо гүйцэтгүүлдэг
- Зураг, дүрслэл, нэмэгдмэл элемент ихтэй байвал уран бүтээлч сэтгэлтэй, хэлбэр хөөцөлдөгч
- Дээрх хувийн онцлог шинж тэмдгүүдийг хослуулсан бол өөртөө дүгнэлт хийдэг үйл ажиллагаагаа хамгийн зохистой болгохыг эрмэлзэж байдаг
6. Гарын үсгийн хөдөлгөөний чиглэл
- Зүүн тийш налалттай гарын үсэгтэй хүмүүс нь өвөрмөц зан ааштай өөрийн санаснаараа байдаг дураараа
- Баруун тийш налалттай гарын үсэгтэй хүмүүс нь юманд нухацтай, тогтвортой ааш зантай, бусадтай түргэн ойлголцолд хүрдэг юманд нухацтай, тогтвортой ааш зантай, бусадтай түргэн ойлголцолд хүрдэг
- Босоо: ямар ч тохиолдолд биеэ барих өндөр чадвартай, урьдчилж харах мэдрэмжтэй, ухаалаг чамбай
- Тодорхойгүй чиглэл налалтгүй холимог бол нууцлаг, бодлоосоо өөр зүйл ярих хандлагатай
- Хэвтээ бол сэтгэл санаа, оюун ухаан сэтгэцэд нийлээд өөрчлөлттэй, эрүүл бус
7. Гарын үсгийн төгсгөлийн элементийн чиглэл
- Төгсгөлийн элементийн чиглэл нь дээш чиглэлтэй бол өөдрөг, өөртөө итгэлтэй
- Төгсгөлийн элементийн чиглэл нь доош чиглэлтэй бол гутранги, аймтгай, өөртөө итгэлгүй
- Төгсгөлийн элемент нь шулуун бол тогтвортой, асуудалд сэтгэлээсээ ханддаг
8. Төгсгөлийн элементийн хэмжээ
- Гарын үсгийн төгсгөлийн элемент нь урт байдал бусдын үгийг сонсох дургүй, юмыг тал бүрээс нь эргэцүүлэн боддог
- Гарын үсгийн төгсгөлийн элемент нь богино байх тусам аливаад ач холбогдол өгдөггүй, хэнэггүй зантай
9. Гарын үсгийн нэмэлт элемент
- Гарын үсгийн доогуур зураастай бол хувиа

хичээсэн, өөрийн гэсэн бодолгүй бусдын хараат байдалтай

- Дээгүүр зураастай бол нэр төрд дуртай, түүнийгээ гүйцэтгүүлэхийн тулд юу ч хийхээс буцахгүй

- Гарын үсгэн дээгүүрээ хөдлөн зураастай бол өөртөө шүүмжлэлтэй ханддаг, эргэлзээ ихтэй, өөрийгөө үнэлдэггүй, бусдыг илүү үнэлж хүндэтгэдэг

10. Гарын үсэг гаргацтай байх тусам тухайн хүнийг ойлгоход хялбар, нээлттэй хүмүүс байдаг

Уг аргыг зөвхөн гар бичмэлийн ерөнхий сэтгэц графологийн дүн шинжилгээ хийхэд төдийгүй бичгийн хэвэнд илрэх сэтгэцийн илрэл хоорондын харилцааг тогтооход ашиглаж болох нь судалгаанаас харагдаж байна. Тухайлбал, гар бичмэлийг үйлдэгчийн сэтгэл санаа бие махбодийн өөрчлөлт\ сэтгэлийн хөөрөл, гутрал, эрүүл мэндийн байдал, амьдралын хэв маяг, илчлэгдэхээс болон ял шийтгэлээс айх айдас\ зэргээс шалтгаалан гар бичмэлийн хувийн онцлог шинж тэмдгүүдэд өөрчлөлтүүд гардаг.

Сэтгэл хөдлөл нь тархины бүтцийн тодорхой хэсгүүдийн үйл ажиллагаатай холбоотой гэсэн нэлээд цэгцтэй онолын үзэл баримтлалыг анх америкийн невропатологич Ж. Пейпец үндэслэжээ. Тэр сэтгэл хөдлөлийн үед тархины түргэн цуцалт (субстрат) үүсгэдэг тархины бүтцийн нэгдмэл системийн талаар таамаглал дэвшүүлжээ.

Графологийг ашиглах хууль зүйн шинжлэх ухааны үндэс. Графологи зүйн мэдлэгийг өнөөдөр гол төлөв гэмт хэргийг илрүүлэх, мөрдөх практикт өргөн ашиглаж байна. Энэ утгаараа графологи зүй нь криминалистикийн шинжлэх ухаантай нягт холбоотой бөгөөд түүний криминалистикийн онол, криминалистикийн техник зүй, криминалистикийн тактик зүй, криминалистикийн арга зүйн салбарт бий болсон мөрдлөг, зөвлөмж, онолын үзэл баримтлал нь графологийг гэмт хэрэг илрүүлэх, мөрдөх ажиллагааны явцад ашиглах шинжлэх ухааны хөрс суурь нь болно. Тийм ч учраас гарын үсэг болон гар бичмэлийн тусламжтайгаар гэмт хэргийн холбогдолтой, сэтгэцийн үүсэлтэй мэдээлэл цуглуулах арга, барил, хэрэгслийг судалдаг мэдлэгийн салбарыг «криминалистикийн графологи» гэж нэрлэн хөгжүүлж байна.

Графологи зүйн мэдлэг нь криминологийн шинжлэх ухаантай нягт уялдаатай бөгөөд гэмт хэргийн шалтгаан нөхцөл, гэмт хэрэгтэн бие хүнийг судалдаг мэдлэгийн салбарын хувьд криминологийн боловсруулсан зөвлөмж, мөрдлөг графологийн арга зүйн хувьд шийдвэрлэх ач холбогдолтой.¹

Гэмт хэрэгтнийг танин мэдэх, үүнийг үндсэн дээр тухайн этгээдийн криминологи шинжийг тодорхойлох арга зүйг графологит "Мастер граф"-

ыг програмыг ашиглан тухайн хүний сэтгэл зүйн өөрчлөлтийг судлан тогтоодог.

Гэмт явдлын онол, гэмт явдлын шалтгааны онол, гэмт хэрэгтэн бие хүний онол зэрэг криминологийн шинжлэх ухааны хүрээнд бий болсон үзэл баримтлал нь графологи зүйн мэдлэгийг гэмт хэргийг илрүүлэх практикт хэрэглэх шаардлага зүй ёсоор биднээс шаардаж байна.

Графологи зүйн мэдлэг нь хууль зүйн сэтгэц судлалтай нягт холбоотой ба хуульч бие хүн, түүний үйл ажиллагааны агуулга, сэтгэц зүй, гэмт хэрэгтний сэтгэц зүйн онцлог, эрүүгийн хэргийг мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагааны онцлогийг судалдаг мэдлэгийн тогтолцооны хувьд тухайн хавсарга шинжлэх ухааны хүрээнд хуримтлагдсан мэдлэг гэмт хэрэгтэн бие хүний сэтгэц зүйн онцлогийг танин мэдэх боломж олгоно.

Бидний үзэж байгаагаар графологи зүйн мэдлэгийг Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн бичиг-техник судлалын лабораторийн практик ажиллагаанд даруй нэвтрүүлэх, идэвхтэй ашиглаж эхлэх асуудал тусгай зорилт болон тавигдаж байна.

Графологи зүйг эрүүгийн гэмт хэргийг илрүүлэх, мөрдөхөд ашиглах шаардлага эрх зүйн зохицуулалт өнөөдөр манай улсын Хууль сахиулах байгууллагууд тэр дундаа Шүүх шинжилгээний байгууллагын өмнө тулгамдаж байна.

Эрүүгийн хэргийг мөрдөх явцад бодит үнэнийг тогтоохын тулд хэргийн нөхцөл байдлыг тал бүрээс нь судлах эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны тусгай зарчим байдаг. Уг зарчмын мөн чанар нь шүүх, прокурор, мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгч нь эрүүгийн хэргийн бүх нөхцөл байдлыг тал бүрээс нь бүрэн бодитой судлахын тулд хуулинд заасан бүх арга хэмжээг авах үүрэгтэй байдагт оршино.

Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах явцад хэргийг тал бүрээс нь судална гэдэг бас сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг яллах ба цагаатгах, түүнд хүлээлгэх хариуцлагыг хөнгөрүүлэх ба хүндрүүлэх бүхий л байдлыг тогтооно гэсэн хэрэг мөн. Бүх талыг хамарч шинжилгээ судалгаа явуулах зайлшгүй нөхцөл нь эрүүгийн хэрэг дээр ажиллагаа явуулахдаа хэргийн байдлаас урган гарсан бүхий л зүйл, тухайлбал, гэмт хэргийн арга, хэргийг үйлдсэн байж болох этгээд, гэмт хэргийн сэдэлт, шалтгаан зэрэгт хамаарах алив таамаглалыг шалгах явдал юм².

Эдгээр таамаглалыг шалгаж бодит үнэнийг тогтоож чадах, олон улсын практикаар нэгэнт туршигдаж батлагдсан аргын нэг бол графологийн шинжлэх ухаан мөн.

Хэрэв аливаа баримт сэлт, мэдээлэл нь, нэгдүгээрт: зөвхөн гэмт хэргийн нөхцөл байдлын талаарх баримт сэлт, мэдээлэл байх ёстой; хоёрдугаарт, ЭБШ

¹ Болдбаатар, Ж., "Гэмт хэрэг илрүүлэхэд полиграф ашиглах ажиллагаа" УБ, 2014 он

² Б.Бат-эрдэнэ. Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй. Ерөнхий анги. УБ., 2004.

хуулинд заасан үндэслэлээр олж авсан байх ёстой; гуравдугаарт, энэ нь зохих үндэслэлээс гадна хуульд заасан журмын дагуу цуглуулсан байх ёстой гэж үзвэл графологийн арга зүйг эрүүгийн процессын ажиллагаанд ашиглах эрх зүйн орчин ямар нэгэн хэмжээгээр бүрдсэн гэж ойлгож болно.

Сүүлийн жилүүдэд гадаадын улс орнуудын хууль сахиулах байгууллагын практикт, тухайлбал ОХУ, Казахстан,-д Графологийг зөвхөн шуурхай-эрэн сурвалжлах ажлын (гүйцэтгэх ажлын) чиглэлээр бус, түүнчлэн нотлох баримт цуглуулах зорилгоор графологийг ашиглан шүүх-сэтгэцийн шинжилгээ хийх хэлбэрээр өргөн ашиглаж эхлээд байна.

Графологийн мэдлэгийн салбар анхлан шинжлэх ухаан, технологийн өндөр хөгжил бүхий улс орнуудад, тухайлбал АНУ, Франц, ХБНГУ –д үүсэж хөгжсөнтэй холбоотойгоор өнөөдөр дэлхийн ихэнх улсын тусгай албад эдгээр орны мэргэжилтнүүдийн боловсруулсан арга зүй, тоног төхөөрөмжийг ашиглаж байна.

Дүгнэлт, санал

1. Графологийн мэдлэгийн салбарт түгээмэл хэрэглэдэг ойлголт, нэр томьёо зэргийг судлах, хууль зүй, сэтгэц судлал, эрүүл мэнд, техникийн шинжлэх ухааны үүднээс тэдгээрийг нэг мөр ойлгох, цаашид уг мэдлэгийн тогтолцоог бүхэлд нь хөгжүүлэх зорилгоор «графологи зүй», «графологи судлал», «графологи шинжилгээ зүй», зэрэг шинжлэх ухааны өөрийн оронд дэлгэрүүлэх бий болгон тодорхойлох шаардлагатай.
2. Графологи шинжилгээ зүйн орчинд бий болох монгол хүний сэтгэцийн онцлогийг судлах, түүнийг танин мэдэх шаардлагатай.
3. Графологийн арга зүйн үр өгөөжийг дээшлүүлэхэд графологийн Мастер-графын програм худалдан авч, судлан өөрийн орны гэмт хэрэг илрүүлэх практикт нэвтрүүлэх.

НОМ ЗҮЙ

1. Ж. Болдбаатар :Гэмт хэрэг илрүүлэхэд полиграф ашиглах ажиллагаа.
2. Кравченко, В. И. Санкт_Петербург 2006
3. Щеголев, И. Тайны почерка/ И. Щеголев. СПб.: Питер, 2004
4. Рамендик, Д. М. Загляни внутрь себя. Психологическое тестирование — серьезно, но доступно / Д. М. Рамендик, М. Г. Рамендик, Инт психотерапии. М., 2001.